



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 6/1.

Хэрлэн сум

Хөдөлмөрийн гэрээг цуцалж,
ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга Ц.Төвшинтөгс нь ажлаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ бичгээр гаргасан тул 2018 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээг цуцлан үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ц.Төвшинтөгстэй холбогдох тооцоог зохих хууль, журмын дагуу хийж дуусгахыг нягтлан бодогч /С.Болортуяа/-д даалгасугай.

3. Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын даргын ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Г.Лхагвахатан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Мөнгөнзул	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Сүнжидмаа	-Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын нярав

4. Чуулгын даргын ажлыг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр хүлээлцүүлэхийг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

D:\My Documents\Захирамж 2018.doc

01 006